



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАЦЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhlан@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025-07-04 № УИХ-03/8407
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Түгээмэл тархацтай ашигт малтмалын” тухай хууль -д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.АЛДАРЖАВХЛАН

0000000209



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhlan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.26 № УИХ-03/7936
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын Их Хурлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1.8-т заасны дагуу “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр баримт, бүрдүүлбэрийг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлж өгөхийг хүсье.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт³⁶ хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.АЛДАРЖАВХЛАН



0000000199



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.АЛДАРЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.06.06 № ХТ / 1632

танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Танаас санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ⁰² хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.УЧРАЛ

000255009715

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“24.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн үзэл баримтлалд Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглах хайрга, дайргыг нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах Туул голоос их хэмжээгээр олборлож байгаа нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа талаар дурдсан байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасныг хуулийн төслийн үзэл баримтлалын хууль зүйн үндэслэл, шаардлага хэсэгт нэмж тусгах боломжтой эсэхийг нягтлах.

2.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 3.1.4-т “...уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал”-ыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгахаар заасны дагуу хуулийн төслийг дагалдуулан боловсруулах бусад хуулийн төслийн асуудлыг тодорхой болгох.

3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3-т түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д “түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан” бол тусгай зөвшөөрлийг цуцлахаар тусгасан байх боловч уг дүгнэлтийг гаргах эрх бүхий субъект тодорхойгүй байгааг анхаарах.


4.Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-аар улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг саадгүй, шуурхай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах харилцааг зохицуулдаг.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна” гэж заасны дагуу хуулийн төсөлтэй холбогдуулан дээрх журмаар зохицуулж байгаа харилцааг хуульчлах шаардлагатай эсэхийг нягтлах, мөн нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт явуулж буй түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааны талаар статистик, тоо баримт болон нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдээлэл тодорхойгүй байх тул холбогдох тооцоо, судалгааг нарийвчлан хийх.

Түүнчлэн, хуулийн төсөл батлагдсанаар одоо үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдөх эсэх, хэрэв хөндөгдөх бол хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалт хуулийн төсөл болон холбогдох судалгаанд тодорхойгүй байх тул уг асуудлыг нягтлах, шаардлагатай тохиолдолд шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгах.

5.Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үнэлнэ” гэж, мөн хуулийн 17.3-т “Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна” гэж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж тус тус заасантай нийцүүлэн хуулийн төслийг хэрэгжүүлснээр төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлт болон хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж, хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангах.

6.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Дөрөвдүгээр бүлгийн 3.1.3-т “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахдаа зүйл, хэсэг, заалтын дугаарлалтыг дарааллаар бус харин өөрчлөлт оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн зүйлд хамаарахаас эхлээд дараа нь хэсэг, заалтад хамаарахыг бичнэ. Зүйл (заалт) дотор дугаарлалтын дарааллыг баримтлан бичнэ. Энэ зарчим хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бүх төрөлд адил байна” гэж заасантай нийцүүлэн хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, мөн хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийн хэл зүйн найруулгыг монгол хэл, бичгийн дүрмийн дагуу хоёрдмол утгагүй, тодорхой байдлаар бичиж, хууль зүйн техникийн шаардлагыг хангахад анхаарах нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ:
ХУУЛЬ САНААЧЛАГЧ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Ж.АЛДАРЖАВХЛАН

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т заасан Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилтын хүрээнд Монгол орны усны сав газрын хил хязгаарыг засаг, захиргааны нэгжийн хилийн заагтай уялдуулан оновчтой болгож, сав газрын захиргааны хүний нөөцийг чадавхжуулах, Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг "усны сан бүхий газар"-т тооцохоор хуульчилсан.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газраас ирүүлсэн мэдээллээр гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 50 дугаар тогтоолоор хамгаалалтын бүстэй давхцалтай 46 зөвшөөрөл олгогдсон тогтоогдож, улмаар тусгай зөвшөөрлийн цуцалсан, мөн хамгаалалтын бүстэй давхцал үүсгэсэн 15 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгааг дурджээ.

Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг 100 хувь нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдэж байна. Цаашдаа усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл

ажиллагааг үе шаттай зогсоох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээрх эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүсч байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар гомдол, мэдээлэл гаргахад түүний мөрөөр нөлөөллийн үнэлгээ хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага үүсч байна.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

Мөн Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч, ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхой хуульчлаагүй.

Иймд усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны

хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд бүрэн нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т заасан Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилтын хүрээнд Монгол орны усны сав газрын хил хязгаарыг засаг, захиргааны нэгжийн хилийн заагтай уялдуулан оновчтой болгож, сав газрын захиргааны хүний нөөцийг чадавхжуулах, Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг “усны сан бүхий газар”-т тооцохоор хуульчилсан.

Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг 100 хувь нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдэж байна. Цаашдаа усан сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттай зогсоох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээрх эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүсч байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

Мөн Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын

хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч, ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхой хуульчлаагүй.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж хуульчилсан зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар гомдол, мэдээлэл гаргахад түүний мөрөөр нөлөөллийн үнэлгээ хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага үүсч байна.

Иймд усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олгогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх үндэслэл, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаар дүгнэлт гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг нарийвчлан, тодорхой зохицуулах шаардлагад үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар болон Усны газраас усны сан бүхий газарт учруулсан хохирлын талаарх холбогдох судалгааг авсан, тэр дундаа түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт явуулснаас эвдэрч, доройтсон газрын талаарх статистик мэдээллийг авсан, мөн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газраас хамгаалалтын бүстэй давхцалтай зөвшөөрөл болон энэ чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээллийг тус тус авсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж, суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

Мөн Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхой хуульчлах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж хуульчилсан зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олгогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх үндэслэл, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаар дүгнэлт гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг нарийвчлан, тодорхой зохицуулах шаардлагад үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Уг хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар болон Усны газраас усны сан бүхий газарт учруулсан хохирлын талаарх холбогдох судалгааг авсан, тэр дундаа түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт явуулснаас эвдэрч, доройтсон газрын талаарх статистик мэдээллийг авсан, мөн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газраас хамгаалалтын бүстэй давхцалтай зөвшөөрөл болон энэ чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээллийг тус тус авсан болно.

Түүнчлэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар иргэд, олон нийтээс санал авахаар d.parliament.mn цахим хуудсанд байршуулсан, иргэд, олон нийтээс санал ирүүлээгүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт:

“11.1.2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглох;”

2/29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг:

“29.4.Орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.”

3/37 дугаар зүйлийн 37.1.5 дахь заалт:

“37.1.5.энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан.”

2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “бүсээс” гэснийг “бүс, усны сан бүхий газраас” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.3 дахь заалтын дугаарыг “11.1.3, 11.1.4” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн заагийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан шинэчлэн тогтооно.

2 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн тогтоосон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн зааг болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасан шаардлагад нийцээгүй тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болно.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т заасан Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилтын хүрээнд Монгол орны усны сав газрын хил хязгаарыг засаг, захиргааны нэгжийн хилийн заагтай уялдуулан оновчтой болгож, сав газрын захиргааны хүний нөөцийг чадавхжуулах, Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг "усны сан бүхий газар"-т тооцохоор хуульчилсан.

Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдэж байна. Цаашдаа усан сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттай зогсоох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээрх эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүсч байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй байна. Мөн уг хуулийн 11 дүгээр зүйлд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын

хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглох бүрэн эрхийг хуульчлах шаардлагатай.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар гомдол, мэдээлэл гаргахад түүний мөрөөр нөлөөллийн үнэлгээ хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага үүсч байна.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу судалсан болно.

Нийслэл Улаанбаатар хотод барилгын салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. 2022 оны байдлаар барилгын салбарт 18,518 аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 7,217 нь үйл ажиллагаа явуулж байжээ. Барилгын салбар эрчимтэй хөгжихийн хирээр түүнд ашиглагдах нийтлэг түүхий эд болох хайрга олборлолтын талаарх эрх зүйн орчныг эргэн харах шаардлага үүсч байна.

Хайрга нь барилгын салбарын чухал түүхий эд бөгөөд түгээмэл тархацтай ашигт малтмалын нэг юм. Үүний гол хэрэглээ нь:

1. Барилгын суурь: Хайрга нь барилгын үндсэн суурийг бэхжүүлэхэд ашиглагддаг.
2. Бетон: Хайрганы ашигт малтмалыг бетон зуурмагт нэмэлтээр ашиглаж, бат бөх байдлыг нэмэгдүүлдэг.
3. Засал чимэглэл: Хайрга нь гадаргуугийн засал чимэглэлд, замын дэвсгэр болон бусад барилгын ажилд хэрэглэгддэг.
4. Ус зайлуулах систем: Хайрга нь усны урсгалыг хянаж, ус зайлуулах системд ашиглагддаг.

Улаанбаатар хот орчмын голын ай сав, усан сан бүхий газарт хайрга олборлох үйл ажиллагаа нь дараах сөрөг нөлөөллийг үүсгэж байна. Үүнд:

1. Усны чанар муудах: Хайрга олборлох явцад голын усны чанар бохирдож, органик бодис болон хүнд металлын агууламжийн хэмжээг нэмэгдүүлдэг.

2. Голын урсацын өөрчлөлт: Хайрга олборлолт нь голын урсац, гүн, флотын хэмжээ, урсацыг өөрчилж, экосистемд сөргөөр нөлөөлж байна.

3. Экосистем алдагдах: Хайрга олборлолт нь голын эрэг, усны орчны амьдрал, ургамал, ан амьтдыг устгах эрсдэлд оруулдаг,

4. Газарзүй, хөрсний эвдрэл: Хайрга олборлолт нь хөрсөнд эвдрэл үүсгэж, хөрсний чанарыг муутгах өндөр эрсдэлтэй юм. Эдгээр сөрөг нөлөөллүүдийг багасгахын тулд хариуцлагатай олборлолтын аргачлалыг хэрэгжүүлэх, байгаль орчны хамгааллын хуулиудыг эргэн харж, голын ай сав, усны хамгаалалтын сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй эргэн харах шаардлагыг үүсгэж байна.

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй болно.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагад зөвхөн ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмал дотроос барилгын салбарын үйл ажиллагаанд нийтлэг ашиглагддаг хайрга, дайргыг гол, мөрний сав газраас олборлож байна. Гол мөрний сав буюу усны сан бүхий газарт юу хамаарах талаар Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг ойлгохоор хуульчилсан байдаг. Гэтэл түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17.4 дэх хэсэгт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглох зайг тодорхойлохдоо "Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор" гэж тогтоосон бөгөөд үүнд дээр дурдсанаар усны тухай хуульд заасан "усны сан бүхий газар" шууд тодорхойлон хуульчлаагүй байна.

Мөн "ногоон бүс"-д ямар нутаг дэвсгэр хамаарах талаар тодорхойлолт байхгүй, ойн тухай хууль, газрын тухай хууль, хот байгуулалтын тухай хууль зэрэгт ногоон бүс гэж нэр томъёог ашигласнаас үүнд яг ямар газар хамаарах талаар нарийвчлан тодорхойлоогүй ерөнхий нийтлэг утгаар ашиглаж байна. Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17.4 дэх хэсэгт

түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглох хэсэгт усны сан бүхий газрыг хамааруулан тодорхойлох шаардлага үүссэн байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч, ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхой хуульчлаагүй.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь цаг үеийн хувьд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай, иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрүүл, аюулгүй орчин амьдрах эрх болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй тулгамдаж байгаа дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгод нийцсэн байна.

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж, дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Нэмэлт зардал шаардагдахгүй

Тав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариуцлах замаар дүгнэлтийг гаргалаа.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		

1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
2.Хүний эрхийг	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		
	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	

хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Шаардлагагүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			Шаардлагагүй
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх			Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
			Үгүй	

1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	

захиргааны зардлын ачаалал				
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

9.Төрийн захиргааны байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		

	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	

	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	

Зургаа. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

6.1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалыг удирдлага болгов.

6.2. Усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттай зогсоох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээрх эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндсэн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулах зүйл, хамрах хүрээ нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон дээрх зорилгыг хангах боломжтой байна. Тухайлбал:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй тул хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулж суурьшлын болон ногоон бүс, усны сан бүхий газраас 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглох зохицуулалтыг тусгасан байна.

Мөн Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч, ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлох шаардлагад үндэслэн Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглох зохицуулалтыг нэмэх зохицуулалтыг тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод нийцсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаар иргэдээс гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэх, энэхүү гомдол үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд эрх зүйн ямар үр дагавар үүсэх талаар хуульд нарийвчлан тодорхойлсон зохицуулалт байхгүй. Иймд уг хуулийн төсөлд тусгаснаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах зохицуулалтыг нэмж тусгаснаар үүсч буй дээрх асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой байна.

Иймд усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай

зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгодоо хүрэх боломжтой,
нийцсэн байна.

---o0o---

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭ**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т заасан Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилтын хүрээнд Монгол орны усны сав газрын хил хязгаарыг засаг, захиргааны нэгжийн хилийн заагтай уялдуулан оновчтой болгож, сав газрын захиргааны хүний нөөцийг чадавхжуулах, Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг 100 хувь нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдэж байна. Цаашдаа усан сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттай зогсоох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээрх эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүсч байгааг дурдаад Мөн үзэл баримтлалд дурдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар гомдол, мэдээлэл гаргахад түүний мөрөөр нөлөөллийн үнэлгээ хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг нарийвчлан

зохицуулах шаардлага үүсч байна гэж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг тодорхойлжээ.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтууд нь практикт хэрхэн хэрэгжиж боломжтойг тогтоох үүднээс энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Энэхүү хэрэгжилтийн үнэлгээ хийх зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

2.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн зорилт нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”¹ гэжээ.

2014 оноос хэрэгжсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дээрх зорилт, үзэл баримтлал нь түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, хайх тусгай зөвшөөрөл олгох, цуцлах үйл ажиллагаа болон ашиглалтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байна гэж үзсэн тохиолдолд иргэнээс гомдол гаргах, мэдээлэл хүсэх эрх хангагдсан эсэх, гомдлын мөрөөр байгаль орчинд сүүсэх нөлөөллийн үнэлгээ гаргах, сөрөг нөлөөлөл бүхий үнэлгээ гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах түүнээс үүсэх үр дагавартай холбоотой харилцааг зохицуулж буй бусад хуулийн уялдаа холбоо болон хуулийн зөрчилтэй зохицуулалт үүссэн эсэхийг

¹ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9750>

тодорхойлох зорилгоор хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэн хэрэгжилтийг үнэлнэ.

2.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол хэм хэмжээг тодорхойлоход чиглэдэг.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Харин хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим хэм хэмжээг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй.

Иймд энэхүү судалгаагаар түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн явуулж буй үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс гомдол гаргах эрх байгаа эсэх, гомдлын мөрөөр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хэн, хэрхэн хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан байдал нь хуулийн зорилтод нийцэж буй эсэхийг тодорхойлох зорилгоор хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

2.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2.4. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрэх байдал, харилцан уялдааг илрүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудтай танилцаж, байгаа мэдээллийг цуглуулж ашиглах аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

Хүснэгт : “Зорилгод хүрсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

Д/д	Сонгосон зүйл заалт	Зүйл заалтын агуулга
1	1 дүгээр зүйл 2/ 29.4.Орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс гомдол, мэдээлэл гаргах эрхийг хангах, тодорхойлох

ГУРАВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

1 дүгээр зүйл 3/37.1.5.Энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаар байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаар дүгнэлт гарсан тохиолдолд Засаг дарга тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эрхийг тодорхой болгон хуульчлах
---	--

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг цуцлах

үндэслэлүүдийг хуульчилсан боловч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас хамаарч байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах эрх олгогдоогүй байсан тул уг зохицуулалтыг тодорхой болгон хуульчлахаар хуулийн төсөлд тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тависан зорилгод нийцсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Иргэн эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар гомдол, мэдээлэл гаргахад түүний мөрөөр нөлөөллийн үнэлгээ хийх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага үүсч байгаа тул уг харилцааг нарийвчлан зохицуулах, хэрэгжилтийг хангах үндсэн зорилгыг хуулийн үзэл баримтлалаар тодорхойлсон байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулах зүйл, хамрах хүрээ нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангах боломжтой байна.

Тухайлбал хуулийн төсөлд тусгаснаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход зөвхөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлага тавигддаг байсан бол ашиглалтын явцад эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс гаргасан үндэслэл бүхий хүсэлтийг үндэслэн эрх бүхий этгээдээс нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, улмаар байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй нь тогтоогдсон тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг

дарга тусгай зөвшөөрлийг цуцлах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох ач холбогдолтой байна.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь уг хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлж буй тулгамдаж асуудлыг шийдвэрлэх, уг харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг тодорхой болгох зорилгодоо хүрэх боломжтой, нийцсэн байна.

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу шалгах үзвэл:

1.Иргэнд үүсэх зардлыг цаг хугацааны болон шууд бий болох мөнгөн зардал гэсэн үзүүлэлтээр нэг жилд бий болох зардлыг тооцож гаргадаг бөгөөд хуулийн төсөлд иргэнд ямар нэг үүрэг болгосон заалт байхгүй тул түүнд зарцуулах хугацаа, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсэхгүй болно.

2.Хуулийн этгээдэд нэг жилд бий болох хүний нөөцийн болон мөнгөн зардлыг тооцдог бөгөөд уг аргачлалын дагуу дараах зардлын тооцоолол гарч байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т “29.4.Орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.” гэж тусгасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 болон 9 дүгээр зүйлд зааснаар зардлыг төсөл хэрэгжүүлэгч тал буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцана. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2013 оны А/407 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх журам”-н 3.1.1-т “Төсөл хэрэгжүүлэгч нь анхан шатны үнэлгээ, дэлгэрэнгүй үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.”, мөн журмын 3.2.3-т “Үнэлгээний зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.” гэж тус тус тодорхойлсон байна.

Иймд энэхүү зохицуулалтын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотойгоор эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс гомдол гаргасан тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэр гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс байгаль орчинд нөлөөлөх байдлын нэг үнэлгээ хийлгэхэд шаардлагатай зардлыг дараах байдлаар тооцох боломжтой байна.

№	Зардлын ангилал	Үйл ажиллагааны задаргаа	Тоо/Нэгж	Нэгжийн үнэ (төг)	Нийт зардал (төг)
1	Мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх	Байгаль орчны үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр БОНБУ хийлгэх	1 үнэлгээ	25,000,000	25,000,000
2	Талбайн судалгаа, газар дээрх хэмжилт	Дэлгэрэнгүй хэмжилт, хөрс, ус, агаарын дээж авч шинжилгээ хийх	1 төсөл	5,000,000	5,000,000
3	Шинжилгээний лабораторийн зардал	Хөрс, ус, агаар, дуу чимээний хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн шинжилгээ	10 сорьц	300,000	3,000,000
4	Орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх уулзалт	Орон нутгийн олон нийтийн оролцоог хангах зөвлөлдөх уулзалтын зохион байгуулалт (түрээс, хэвлэл, унаа)	1 удаа	1,500,000	1,500,000
5	Тээвэр, зочид буудал, томилолт	Үнэлгээний багийн аяллын зардал (3 хүн, 3 хоног, орон нутгийн чиглэлд)	3 хүн * 3 хоног	250,000	2,250,000
6	Нотариат, баталгаажуулалт, тайлан хэвлэлт	БОНБУ тайланг хуулийн дагуу хэвлэх, баталгаажуулах	1 тайлан	500,000	500,000
7	Нөөц зардал (10%)	Үнийн хэлбэлзэл, нэмэлт зөвлөх үйлчилгээ	—	—	3,725,000
8	Нийт			41,975,000 төгрөг	

3.Төрийн байгууллагад хүний нөөц шинээр болох, шинэ бүтэц бий болохтой холбоотой зардлыг нэг жилээр тооцож гаргах бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаас харахад ийм төрлийн зардал бий болохооргүй байна.

---o0o---